

## **ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2022 ОНЫ 08 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ**

### **НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД**

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, аймгийн Засаг даргаас 6 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан.

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгуулан, 7 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, аймгийн Засаг даргад ирүүлсэн өргөдлийн дагуу олон улсын уралдаан, тэмцээнд оролцох 2 баг, хамт олон, 3 иргэнд аймгийн Засаг даргын нөөцөөс 4.5 сая төгрөгийн тусламж, дэмжлэг үзүүлсэн.

Аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/243 дугаар захирамжаар “Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажил хангуулах ажлын хэсэг”-ийг томилон, аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 01 дугаартай “Өвөлжилт, хаваржилт болон ургац хураалтын бэлтгэл ажил хангуулах тухай” албан даалгаврыг гарган ажиллаж байна. Холбогдох ажлын хэсэг аймгийн хэмжээнд Засгийн газрын 2022 оны 07 дугаар сарын 20-ний өдрийн 277 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 09 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах чиглэлээр хуралдан, төлөвлөгөө гарган ажиллаж байгаа бөгөөд албан даалгаврын хэрэгжилтийг газар дээр нь шалган, ус дулаан, цахилгаанаар хангагч болон хүнс, хөдөө аж ахуйн газар, бусад холбогдох орон нутгийн байгууллагууд, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгч нарт чиглэл өгөн ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Монгол улсын Засгийн газар, Бүгд найрамдах Солонгос улсын Засгийн газар хооронд байгуулагдсан хөнгөлөлттэй зээлийн гэрээний дагуу “10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл”-ийн гүйцэтгэгчээр БНСУ-ын “Бьюксан инженеринг” ХХК шалгарч, Эрчим хүчний яамнаас ажил эхлүүлэх зөвшөөрөл өгсөн бөгөөд барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг ханган талбайг хашаалж, суурийн ажлыг эхлүүлэхэд бэлэн болсон.

Монголын Хөдөө аж ахуйн хоршоологчдын 30 жилийн ойн хүрээнд “Хоршоолсон хэлбэрээр төгс дэлхийг бүтээе” улсын зөвлөгөөнийг 2022 оны 08 дугаар сарын 15, 16-ны өдөр Говьсүмбэр аймагт зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд 21 аймаг, нийслэлийн 248 төлөөлөл оролцож, хоршоологчдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, аймгийн төвийн “Сүмбэр Гарден” соёл, амралтын хүрээлэнд мод тарьж “Хоршооллын Төгөл” байгууллаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессийг боловсронгуй болгох үндэсний чадавхыг бэхжүүлэх төсөл” /NAP in Mongolia/- тэй хамтран “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийг сайжруулах нь” улсын зөвлөгөөнийг 2022 оны 08 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд БОАЖЯ, 21 аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын удирдах болон гүйцэтгэх албан хаагчид, байгаль хамгаалагчид, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн байгууллагуудын 250 төлөөлөгч оролцож, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр нөлөө, стратеги, ололт, амжилт, цаашид анхаарах зүйлсийн талаар зөвлөлдлөө.

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу “Шилдэг тохижилт, бүтээн байгуулалтын уралдаан”-ыг зарлалаа. Тус уралдааныг 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр дүгнэх бөгөөд иргэн, аж ахуйн нэгж байгууллага гэсэн ангиллаар зохион байгуулж байна.

### **ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлэн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллаж байна.

2022 оны 08 дугаар сарын татварын орлогын төлөвлөгөө 6,392,695.3 мян.төгрөг байгаагаас гүйцэтгэл 6,264,109.0 мян.төгрөг буюу 97 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс улсын төсвийн орлогын төлөвлөгөө 828,053.0 мян.төг, хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1,597,006.0 мян. төгрөг буюу 100 хувь, аймгийн төсвийн орлого 1,062,0949.0 мян.төгрөг буюу 74 хувь, сумдын төсвийн орлого 3,604,154.0 мян.төгрөг буюу 87 хувийн тус тус гүйцэтгэлтэй байна.

Аймгийн хэмжээнд татвар төлөгч хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж байгаа бөгөөд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр 642 хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байсан бол 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 692 болж өссөн байна. Үүнд: ХК-1, ХХК-358, ББН-5, ЗБН-9, Хоршоо-29, ХЗХоршоо-1, ОНӨҮГ-6, Салбар-66, төсөвт болон төрийн бус байгууллага, сан ОНБ-217 бүртгэлтэй байна.

**Санхүүгийн хяналт, аудитын чиглэлээр:** Аймгийн хэмжээнд нийт төсвийн болон орон нутгийн өмчит 75 байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. 2022 оны 07 сарын 30-ны байдлаар шилэн дансны хуулийн хэрэгжилт 96.6 хувьтай байна.

Санхүүгийн хяналт, аудитын албанаас 8 дугаар сард Шивээговь сумын соёлын төв, Баянтал сумын Орон нутгийн хөгжлийн сан, аймгийн 2020-2021 оны хөрөнгө оруулалтын ажлын санхүүгийн үйл ажиллагаанд тус тус хяналт шалгалт хийсэн. Баянтал сумын 2021-2022 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд 34,400.08 мян.төгрөгийн санхүүгийн зөрчил илрүүлж, зөвлөмж хүргүүлсэн. Аймгийн 2020-2021 оы хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд 805,661.8 мян. төгрөгийн зөрчил илэрч 6,060.6 мян.төгрөгийн нөхөн төлбөрийн акт, 532,622.3 мян.төгрөгийн хугацаатай албан шаардлага, 266,978.8 мян.төгрөгийн зөвлөмж өгөөд байна.

#### **ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Төрийн архив:** Архивийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Хөмрөг-1, Хадгаламжийн нэгж- 3, Заалт -235, Хүний нэр- 1337, Байгууллагын нэр- 235, Газарзүйн нэр- 716, Холболт- 235, Хуудас-269 баримтыг программд холбож ажилласан. Архивын тасгаас 2022 оны 08 дугаар сард 4 иргэнд лавлагаа хуулбар гаргаж үйлчилгээ үзүүлсэн.

**Улсын бүртгэл:** “Цахим үндэстэн” хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд 10523 иргэнд тоон гарын үсэг олгохоос 2385 иргэнд олгож, иргэдэд тоон гарын үсэг олгох үйл ажиллагаа 22.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 2022 оны 08 дугаар сард дараах чиглэлээр нийт 692 иргэнд төрийн үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнд:

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан - 10
- Иргэний үнэмлэх шинээр олгосон - 30
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо - 23
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 7
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо - 2
- Үрчлэлтийн бүртгэлийн тоо - 0
- Овог, нэр өөрчлөлтийн бүртгэлийн тоо - 2
- Эцэг тогтоолтын бүртгэлийн тоо - 1
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 4
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн -15
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо –33
- Тоон гарын үсэг олголт- 109

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 3

- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 36
- Гэрээний бүртгэл - 49
- Барьцааны гэрээний бүртгэл - 148
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга - 5

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 2
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт - 4
- Татан буугдсан хуулийн этгээдийн бүртгэл - 0

Архивын чиглэлээр:

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар - 0
- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар - 76
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар - 133

**Хууль сахиулах чиглэлээр:** Аймгийн цагдаагийн хэлтэст 2022 оны 08 дугаар сард 128 гомдол мэдээлэл ирсэнээс гэмт хэргийн 18, зөрчлийн 110 хэрэг нээж шалгасан. Мөн зөрчил үйлдсэн 14 иргэнийг 2,410,000.0 төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 59 иргэнийг эрүүлжүүлж, 42 иргэнийг шүүхээр баривчлуулан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 61 иргэний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, эргүүл, шалгалтын ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж, 8 дугаар сард 39 санамж, анхааруулга, зөвлөмж, 17 видео шторк, бусад 17, нийт 73 сургалт, сурталчилгааны мэдээ, мэдээллийг цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр иргэдэд хүргэн ажилласан бөгөөд давхардсан тоогоор 216 алба хаагч гудамж талбай, олон нийтийн газруудад эргүүл, хяналт шалгалтыг зохион байгуулж, зөрчил гаргасан 2260 иргэнийг 64,522,500.0 төгрөгөөр торгож, захиргааны арга хэмжээ авч ажилласан.

Цагдаагийн хэлтсээс орон нутгийн хэмжээнд “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” арга хэмжээг зохион байгуулан, Баянтал, Шивээговь сумдын нутаг дэвсгэрт авто замын хөдөлгөөнт эргүүл, Улсын чанартай авто замын дагуу төмөр замын 16 дугаар зөрлөг орчимд хөдөлгөөнт түр постыг ажиллуулж байна.

Цагдаагийн хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Мэргэжлийн хяналтын газраас хамтран “Хүүхэд-хөдөлмөр” аян зохион байгуулж, 38 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Согтуугаар үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осол, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийг бууруулах, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор **"Согтуу"** хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, Цагдаагийн Хэлтсийн нийт 22 алба хаагч 11 чиглэлд нэгдсэн хяналт, шалгалтанд үүрэг гүйцэтгэлээ.

**Мэргэжлийн хяналтын газар:** Улсын байцаагчийн хяналт шинжилгээ болон иргэн, аж ахуй нэгжийн хүсэлтээр 25 сорьцонд 103 үзүүлэлтээр хими, нян судлалын хорио цээрийн шинжилгээг гүйцэтгэн хяналт тавьж, хариуг баталгаажуулсан. Шаардлага хангаагүй сорьц илрээгүй.

Дорнод аймгийн Сэргэлэн сумаас 8 хурган хуц, 3 мал эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээгүй, бүртгэлд хамруулаагүй худалдан авч, зөвшөөрөлгүйгээр хээлтүүлэгчээр ашиглаж байсан иргэнийг “Зөрчлийн тухай” хуулийн 13.9.2 дах заалтын дагуу 50,000 төгрөгөөр торгож, Сүмбэр сумын Засаг даргын захирамжаар 21 хоногийн хязгаарлалтын дэлгэмд оруулсан байна.

**Онцгой байдлын газар:**

Аймгийн хэмжээнд гал түймрийн объектын дуудлага 1 удаа бүртгэгдэж, 2,5 сая төгрөгийн эд хөрөнгө гал түймэрт өртөж хохирол учирч, 45.0 сая төгрөгийн эд хөрөнгийг авран хамгаалсан байна.

Монгол Улсын Шадар Сайдын баталсан “Худалдаа олон нийт, үзвэр үйлчилгээний барилга байгууламжид Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хуулиуд, стандарт норм, норматив баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын удирдамж”-ийн дагуу Сүмбэр, суманд үйл ажиллагаа явуулж буй худалдаа үйлчилгээний газруудад гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2022 оны 08 дугаар сарын 01-ээс 08 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулж, 20 аж, ахуйн нэгж байгууллагыг хамруулж, зөрчлийг арилгуулан, зөвлөмж өгч ажилласан.

Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг зохион байгуулж 4 байгууллагын 61 ажилтан, албан хаагчийг хамруулж, үер, усны осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголт өгч, гал унтраах дадлага сургууль хийсэн.

Онцгой байдлын газар Сүмбэр сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “НИК” ХХК-ны нефть хангамжийн агуулахын салбарт тактикийн дадлага, сургалтыг агуулахын 23 ажилтан, 1 нэгж техник, Онцгой байдлын газраас 17 алба хаагч, 4 нэгж техник, Цагдаагийн хэлтсийн 14 алба хаагч, 3 нэгж техник, Эрүүл мэндийн газраас 2 алба хаагч, 1 нэгж техник, УС-ДУОНӨГ-ын 1 ажилтан, 1 нэгж техник, нийт 57 алба хаагчид, ажилтан, 9 автомашин, техникийг татан оролцуулж амжилттай зохион байгууллаа.

Онцгой байдлын ерөнхий газар болон Цаг, уур орчин шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээ 21, Онцгой байдлын газрын үйл ажиллагааны чиглэлээр 11 мэдээ, Галын аюулгүй байдлын талаар 3, үер усны ослоос урьдчилан сэргийлэх талаар 31 нийт 66 мэдээг цахим хуудас, олон нийтийн сүлжээнд байршуулан иргэдэд мэдээ, мэдээллийг хүргэсэн бөгөөд go.nema.gov.mn сайтад 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 46021 хандалт хийгдсэн байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Онцгой байдлын шуурхай удирдлагыг төв, сургалтын танхим”-ыг тоног төхөөрөмжөөр хангаж, ухаалаг индэр, дэлгэц, микрофон, спикер, проектор, камер зэрэг тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн.

## **ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Боловсролын чиглэлээр:** Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газраас “Багш нарын бага хурал”-ыг зохион байгуулж, 2022-2023 оны хичээлийн жилийн зорилго, зорилт, үйл ажиллагааг танилцуулан, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа боловсролын байгууллагуудад хичээл сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах чиглэлээр үүрэг даалгавар өглөө. Бага хуралд сургууль, цэцэрлэгийн удирдах албан тушаалтан, 234 багш, ажилчид хамрагдлаа.

Шинэ хичээлийн жил эхлэх бэлтгэл ажлын хүрээнд 1 дүгээр ангид хичээл заах бага ангийн 19, дуу хөгжмийн 5, биеийн тамирын 5, нийт 29 багшийг 3 хоногийн онлайн сургалтанд хамруулж, арга зүйн зөвлөмж өгсөн.

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр:** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 08 дугаар сарын 155 дугаар тушаалын дагуу үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Залуучуудын хөгжлийн сарын аян”-ны хүрээнд “Залууст ээлтэй шийдвэр” цахим уулзалт зохион байгууллаа. Тус уулзалтад аймгийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл болон залуусын төлөөллүүд оролцож орон нутагт залуусын хувьд тулгамдаж буй асуудлыг хэлэлцсэн бөгөөд цахим уулзалтад 32, хэлэлцүүлэгт 20, нийт 54 залуучуудын төлөөлөл оролцлоо.

**Соёл, урлагийн чиглэлээр:** “НҮҮДЭЛЧИН МОНГОЛ -2022” Дэлхийн соёлын фестивалд орон нутгаас соёлын өвийн 7 ай савын хүрээнд 61 соёлын биет болон биет бус өв тээгчид оролцон, соёлын өвийг таниулах, сурталчлах арга хэмжээнд оролцсон бөгөөд Говьсүмбэр аймгийн хувьд “Боржигин өв соёл” –ыг сурталчлан таниулж оролцсон.

**Биеийн тамир, спортын чиглэлээр:** Улаанбаатар хотноо 07 дугаар сарын 22-24-нд зохион байгуулагдсан Жюү жицүгийн Олон улсын тэмцээнд Говьсүмбэр аймгийн баг тамирчид амжилттай оролцож, 2 алт, 3 мөнгө, 3 хүрэл медаль хүртлээ.

Монголын үндэсний спортын VII наадамд аймгаас спортын 5 төрөлд 45 тамирчин хурд хүч авхаалж самбаагаа сорьж оролцсон.

Монголын үндэсний сурын холимог багийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 8 хүний бүрэлдэхүүнтэй оролцож, багийн төрөлд 8 дугаар байрт шалгарч, цол олгох цуваа харваанд 700 гаруй харваачдаас шигшээ харваанд 3 тамирчин шалгарч, 1 тамирчин спортын мастер, 2 тамирчин дэд мастерын болзол хангалаа.

Усан спорт сургалтын төвөөр давхардсан тоогоор нийт 496 иргэнд үйлчилж, анхан шатны сургалтанд 14, давтан сургалт 39 иргэн хамрагдсан байна.

**Эрүүл мэндийн чиглэлээр:**

Үзүүлэлт	2021 оны 08 сар	2022 оны 08 сар
Төрсөн эх	314	217
Гэрийн төрөлт	3	1
Амьд төрсөн хүүхэд	317	215
Амьгүй төрөлт	1	2
Нас баралт	53	54
Эмнэлгийн нас баралт	16	14
Хоног болоогүй нас баралт	5	5
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	1	2
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	1
Эмнэлгээс гарсан хүний тоо	3406	3302
Амбулаторийн үзлэг	67650	68636
Халдварт өвчин	1167	2490

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр:** Тайлант хугацаанд хуваарийн дагуу 49 иргэний 8798,0 мян төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлж, өссөн дүнгээр 132 иргэний 137,496.9 мян.төгрөг санд төвлөрөөд байна

Аймгийн хэмжээнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг өссөн дүнгээр 76 өрхийн 412 гишүүнд 4552.0 мян.төг олгосон. 2022 оны 08 сарын 19-ний өдрийн байдлаар 68 өрхийн 346 гишүүн Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байна. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 2 иргэнийг байнгын, 2 иргэнийг түр ажлын байранд зуучилсан.

Ehalamatj.mn системээр дамжуулан иргэдийн үйлчилгээг бүртгэн, 693 иргэнд хүүхэд асарсны тэтгэмж, 173 иргэнд жирэмсэн эхийн тэтгэмж, 6988 хүүхдэд хүүхдийн мөнгөн тэтгэмж олгосон.

#### **ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

Өвөлжилтийн байдал, цаг агаарын аюулт үзэгдэл, малын тарга хүч зэргээс хамааран нийт бог малын хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироог тооцоход нэг хуцанд 72 хээлтэгч, ухнанд 85 хээлтэгч оногдож, хуц 701, ухна 704 дутагдаж байна. Цаашид дутагдаж байгаа хээлтүүлэгчийг

биотехнологийн аргаар нөхөх, мөн эрүүл бүс нутгаас хээлтүүлэгч авах, өнжөөн төллүүлэх, заазлалтыг сайн хийж эдийн засгийн эргэлтэнд оруулах зэргээр зохион байгуулж байна.

Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд Засгийн газрын 277-р тогтоол, болон Монгол улсын ерөнхий сайдын 09-р албан даалгаврын хүрээнд малчдын түвшинд бэлтгэх өвс тэжээлийн тооцоо, эдийн засгийн эргэлтэнд оруулах малын тоо, өвөлжиж, хаваржих малын тоог тодорхойллоо. Эдийн засгийн эргэлтэнд 133213 толгой мал оруулж, 452011 толгой мал өвөлжиж, хаваржих урьдчилсан тооцоотой байна. Малчдын түвшинд аймгийн хэмжээнд 7436 тн өвс, 1859 тн тэжээл, 389 тн гар тэжээл бэлтгэхээр төлөвлөж, Сумдын Засаг дарга нарт үүрэг чиглэл өгөн ажиллаж байна.

2022 оны ургацын урьдчилсан балансаар 42 га-д тэжээлийн ургамал, 21 га-д төмс, 31.2 на-д хүнсний ногоо тариалж, 42 тн тэжээлийн ургамал, 168 тн төмс, 250 тн хүнсний ногоо хураан авахаар байна. Мөн 6 га-д механик аргаар уринш бэлтгэсэн дүнтэй байна.

Хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох бэлтгэл ажлын хүрээнд 2022 оны 08 сарын 18-ны өдөр тариалан эрхлэгчдэд сургалт зохион байгууллаа. Тус сургалтад нийт 28 хүнсний ногооны тариалан эрхлэгч оролцсон.

**Хүнсний нөөц:** Аймгийн дүнгээр мах 0.4 тн буюу 1, гурил 76.3 тн буюу 55, сүү 3.9 тн буюу 2, төрөл бүрийн будаа 14.8 тн буюу 21, төмс 6.1 тн буюу 4, хүнсний ногоо 5.7 тн буюу 2, элсэн чихэр 3.05 тн буюу 7, давс 2.74 тн буюу 10, савласан ус 16.3 тн буюу 1, өндөг 1.27 тн буюу 5, ургамлын тос 3.17 тн буюу 10 хоногийн нөөцтэй байна.

**Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2021 оны 8-р сарын үнийн мэдээ:** Зах зээлд худалдаалагдаж буй зарим хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ өнгөрсөн сараас 250-800 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Тухайлбал төмс 800 төгрөгөөр, сонгино 250 төгрөгөөр нэмэгдэж, үхрийн мах /цул, ястай/ 500 төгрөгөөр, хонины мах /цул, ястай/ 500 төгрөгөөр, адууны мах /ястай/ 250 төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна. Үнийн мэдээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулан үзэхэд дотооддоо үйлдвэрлэж буй малын мах төрөл тус бүрээр 250-500 төгрөгөөр, төмс, хүнсний ногоо 250-800 төгрөгөөр, сүү 500 төгрөгөөр, гурил 50-150 төгрөгөөр нэмэгдсэн бол импортын бүтээгдэхүүн болох элсэн чихэр 200 төгрөгөөр, цагаан будаа 500-1000 төгрөгөөр, ургамлын тос 1000-1500 төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

№	Бараа бүтээгдэхүүн		Дээд үнэ, төг	Доод үнэ, төг	Өссөн, буурсан
1	Үхрийн мах	Ястай	11000	10000	-500
		Цул	13500	13000	-500
2	Хонины мах	Ястай	9500	8500	-500
		Цул	13000	12000	-500
3	Адууны мах	Ястай	9000	7000	-250
		Цул	10000	9000	
4	Ямааны мах	Ястай	8500	7500	
		цул	11000	10000	
5	Тахианы мах	Гуя	12000	10500	
		мөч	14300	11000	
6	Лууван	монгол	3300	3000	
		хятад			
7	Төмс	монгол	4000	3300	+800
		хятад			
8	Байцаа	монгол	2000	1600	
		хятад			
9	Чинжүү	монгол			
		хятад	10000	8500	

10	Манжин	монгол	2000	1400	
		хятад			
11	Сонгино бөөрөнхий	Монгол	3500	3500	+250
		Хятад			
12	Помидор	монгол	9500	7100	
13	Өргөст хэмх	монгол	8500	7800	
14	Элсэн чихэр	монгол	3300	2900	
15	Будаа	Цагаан задгай кг	4000	3000	
		Шар слава кг	5100	3000	
		Гурвалжин будаа кг	6000	4000	
16	Сүү	Задгай	3000	2800	
		Сүү ХХК 0,5л			
		Сүү ХХК 1л	4300	4000	
17	Тараг	Задгай	3500	3000	
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	5500	3800	
18	Талх	Чойр талх	1650	1500	
19	Өндөг	ОХУ	400	330	
		Монгол	450	400	
20	Алтан тарианы гурил	Задгай дээд	1500	1300	
		Задгай 1-р зэрэг	1560	1400	
		Задгай 2-р зэрэг	1400	1000	
		Савласан д/дээд /	2400	2400	
		Савласан дээд	2200	1800	
		Савласан 1-р зэрэг	1600	1400	
		Савласан 2-р зэрэг	1200	1000	
21	Ургамлын тос	Олейна	10000	9500	
		Алтан	8000	7500	
22	Гоймон	Алейка	2800	2000	
		А/тариа савхан	1800	1000	

### **ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Байгаль орчны чиглэлээр:** “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр ногоон байгууламжийн усалгаа, арчилгааг сайжруулах, Сум дундын ойн ангийг бэхжүүлэх зорилгоор усалгаа, арчилгааны зориулалтын автомашин худалдан авч “Сум дундын ойн анги” ОНӨҮГазарт хүлээлгэн өглөө.

“Цайны зам” Олон Улсын Аялал Жуулчлалын холбоо нь Монгол, Хятад, Орос 3 улсын 24 хотыг эгнээндээ нэгтгэсэн цайны зам дагуу хотуудын хамтарсан хөгжлийг идэвхжүүлэх, аялал жуулчлалыг сурталчлах, харилцан туршлага солилцох, бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдөр бүх гишүүдийнхээ хурлыг цахимаар зохион байгууллаа. Уг хурлаар Говьсүмбэр аймгийг нийт гишүүдийн 100 хувийн саналаар 28 дахь гишүүн орон нутгаар элсүүллээ.

**Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар:** Газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөний дагуу аймаг, сумын Засаг даргын 2022 оны А/223, 2022 оны А/133 дугаар захирамжийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг цахимаар 2022 оны 08 дугаар сарын 02, 09-ны өдрүүдэд газрын цахим биржийн mle.mn хаягаар 4 байршилд зохион байгуулсан.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Боржигин чуулгын барилга угсралтын ажил 60 хувь, Сүмбэр сумын 640 хүүхдийн сургуулийн (2 дугаар сургууль) барилгын ажил 95 хувь, Шивээговь сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын ажил 25 хувь, Шинэ сууршилын бүсэд цахилгаан дамжуулах агаарын шугам татах ажил 100 хувь, Сүмбэр

сумын 5 дугаар цэцэрлэгийн өргөтгөл (150 хүүхдийн цэцэрлэгийн барилга)-ийн ажил 75 хувь, Халуун усны барилгын ажил 25 хувь, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга 55 хувь, Сүмбэр сумын Бурхантын шинэ сууршиллын бүсэд цахилгаан дамжуулах агаарын шугам татах ажил 80 хувийн тус тус гүйцэтгэлтэй байна.

**Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагааны талаар:** Төсвийн ерөнхийлөн захирагчид 2022 онд нийт 15,716,734.5 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 48 бараа, ажил, үйлчилгээ худалдан авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан байна. Үүнээс 46 тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарласан байна. Худалдан авах ажиллагааны явц 95.8 хувьтай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 5 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 4 ажил, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 24 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 22 ажил, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 17 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 16 ажил, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар нийт 2 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 2 ажлын тендер шалгаруулалтыг, Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар нийт 1 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 1 ажлын тендер шалгаруулалтыг тус тус цахимаар зохион байгуулаад байна.

Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Орон нутгийн өмчийн газар харьяа 43 байгууллагын автомашины бүртгэл, тоо ширхэг, татварын өртэй эсэх талаарх мэдээллийг гаргаж тооллогын программд нэгтгэн, автомашинуудыг төвлөрүүлэх, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх ажлаас өмнө байгууллагуудын автомашины татварын өрийг төлөх тухай албан бичиг хүргүүлэн ажиллаж байна.

Засгийн газрын 2020 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 9 дүгээр тогтоол, Аймгийн тооллогын комиссын Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг удирдан зохион байгуулах удирдамжийн дагуу орон нутгийн өмчтэй 43 хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийг нүд үзэж тоолох ажлыг зохион байгуулж дууссан.

Орон нутгийн өмчийн түрээсийн орлогод 08 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 17.9 сая.төгрөг төвлөрөөд байна.

## **ДОЛОО. СУМ, ОРОН НУТГИЙН ТАЛААР**

**Баянтал сум:** Долоо хоног бүрийн 1, 3, 5 дахь өдрүүдэд сумын хэмжээнд нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулж, хог хаягдлыг цэвэрлэж байна.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Хоршоо хөгжүүлэх сангаас журмын дагуу төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулан “Орцог элгэн хоршоо”-нд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгохоор шийдвэрлэсэн. Тус хоршоо нь нийтийн хоол, аялал жуулчлалын үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

**Шивээговь сум:** Хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд сумын төвлөрсөн хогийн цэгийг өргөтгөх, орц, гарцыг сайжруулах ажлыг хийж, 4тн хог хаягдлыг булшилсан.

“Зөв дадал, эерэг өөрчлөлт-Ногоон ирээдүй” аяныг эхлүүлэн сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулж байна.

“Ахмад настаны эрүүл мэндийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд ахмад настангуудыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулж, эрүүл мэндийн зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 18 ахмадыг хамруулаад байна.

**Сүмбэр сум:** Монгол Улсын Шадар сайдын баталсан “Үер усны ослоос урьдчилан сэргийлэх”, “Үер, уснаас үрсээ хамгаалъя” аяны удирдамжийн хүрээнд үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор Сүмбэр сумын үерийн далан суваг, шуудуу, хоолойнуудын ашиглалт, засвар үйлчилгээг сайжруулах, гамшиг осол, эрсдэл, эмзэг байдлыг бууруулах чиглэлээр

Онцгой байдлын газартай хамтран урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулж, иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад зөвлөгөө өгч ажилласан.

Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл 8 дугаар сард 3 бүртгэгдэж, хариу арга хэмжээг авч ажилласан ба нийт кэйсийн шийдвэрлэлт 66.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Бэлчээр хамгаалах, сайжруулах, зүй зохистой ашиглах, оновчтой төлөвлөх, ногоон тэжээл тариалах, малчдыг бүлгийн зохион байгуулалтанд оруулах зорилгоор зохион байгуулагдаж буй “Хөдөөдөө сайхан амьдаръя” аяны ажлын явцыг хянан, мод тооллогоны ажлыг хийж гүйцэтгэлээ. Уралдаанд идэвхитэй оролцож байгаа 12 бүлэг байгаагаас 10 бүлэг ногоон тэжээл тариалж, 5 бүлгийн тариалалт нь амжилттай ургаж, 3 баг нийт улиас, хайлаас, бургас, чавга, бөөрөлзгөнө, алим, чацаргана гэх мэт 7 төрлийн 1017 модыг бэлчээрт тарьж ургуулсан байна.

Сүмбэр сумын 2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Ковш автомашин худалдан авч "Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ-т 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдөр хүлээлгэн өгсөн.

## **ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**